УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2025.01.15 № 1/65
танай 2024.12.02-ны № 8/5020-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ

Тайлан хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 тоот тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.8 дугаар хүснэгтийн дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийн тайланг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 24 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.БЯМБАСҮРЭН

АТА9996 90771.
9023050128

142250122

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ /2024.12.31/

Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв,
ЭМС-ын 2022 оны А/346 тоот тушаал

| № | Шалгуур үзүүлэлт | Өмнөх он 2023 | Тайлант он 2024 | Тайлбар |
|---|---|---|---|---|
| **2.1 Нийтлэг үзүүлэлт** | | | | |
| 1. | Орны фонд ашиглалтын хувь | 79.4% | 77.1% | 2024 онд УНТЭ-т нийт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо 24069<br>2023 онд орны фонд ашиглалтын хувь 79.4% байсан бол 2024 онд 77.1% болж 2.3% буурсан бол 1,5%(n=369)-аар эмчлүүлэгчдийн тоо өмнөх оноос буурсан байна.<br><br>2023 онд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн ор ашиглалтын хувь 79.4 байгаа нь 2.3-аар бага байна<br><br>**Орны фонд ашиглалт /тасаг,төвөөр/**<br><br>МЭТ-д 96%-тай хамгийн өндөр, НСМЗТ 56.6%, ЭЭТ-53,2%-тай хамгийн бага хувьтай байна.<br><br><br><br> |

<table>
<tr>
<td>2.</td>
<td>Дундаж ор хоног</td>
<td>5.8</td>
<td>5.7</td>
<td>2023 оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад 2024 оны эцэст 0.1-оор буурсан байгаа нь 1 удаагийн багаж хэрэгслийн хангамж, ариутгалын чанар, оношилгоо, эмчилгээний шинэ технологи, эмч мэргэжилтэнүүдийн мэдлэг ур чадвар сайжирсантай холбоотой дундаж ор хоног буурч байна. Мөн дотор, мэс заслын тасгуудын орны хүлээгдлийг E-health системээр хянаж эхэлсэн<br><br>Дундаж ор хоног тасаг бүрээр ялгаатай байгаа ба 2023 оны улсын дундаж ор хоног 5.8 байсанаас 0.1-оор бага, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тасагт 23.8 байсанаас манай эмнэлэг 5.2-аар бага байна.<br><br>Дундаж ор хоног /тасаг, төвөөр/<br>- Мэс заслын тасгуудад 3.3-6.3<br>- Дотрын тасгуудад 6.5-9.4-тай байна.<br>- Эрчимт эмчилгээний тасагт дундаж ор хоног 18.5 байгаа нь 2023 оны дундаж /13.5/-аас 4.9-аар их байна.<br>- УНТЭ-т Эрчимт эмчилгээний тасагийг 24 ортой 3 хэсэгт ЭЭТI, ЭЭТII,ЭЭТIII гэсэн зохион байгуулалттай эмнэлгийн А блокийн 1,5,6-р давхарт байрлуулан тусламж үйлчилгээг тасаг төвүүдэд ойртуулан ажиллаж байна<br><br><br><br></td>
</tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3. | Эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь (8-24 цагийн дотор) | Хоног болоогүй нийт 13.8% (n=55)<br><br>Үүнээс:<br>8-24 цагийн дотор нас барсан 58.2% (n=32) | Хоног болоогүй нийт 12.8% (n=49)<br><br>Үүнээс:<br>8-24 цагийн дотор нас барсан 51% (n=25) | 2024 он хоног болоогүй нас баралт нийт нас баралтын 12.8% (n=49)-ийг эзэлж байна<br>2024 онд өмнөх оноос хоног болоогүй нас баралт 1% буурсан<br>Үүнээс:<br>• Хоног болоогүй нас баралтын 0-8-аас доош цагийн нас баралт 48.9% (n=24 тохиолдол)<br>• 8-24 цагийн нас баралт 51% (n=25)-ийг эзэлж байна.<br><br><br>Нийт хоног болоогүй нас баралтын 71,4% (n=35) хөдөө орон нутгийн харъяалалтай тохиолдол эзэлж байгаа нь<br>- Олон эрхтний хавсарсан эмгэгтэй, архаг өвчний төгсгөлийн шатанд орсон<br>- Хэт хүндэрсэн үед хөдөө орон нутгаас тээвэрлэж ирэх<br>- Эсвэл оршин суугаа хаягаа шилжүүлээгүй хотод түр оршин суугчийн бүртгэлтэй<br>- Өрхийн эмчийн хяналтанд орж байгаагүй зэрэгтэй холбоотой<br><br> |


Хоног болоогүй нас баралт / N=49/
/тасгаар/
Тасаг,тевеер
ЯТТ, 12
ЭЭТ, 30
ГЭТ, 2
ЕМЗТ, 1
ЦЭЧШСТ, 1
БШГМЗТ, 1
ЗТ, 2
Тасаг


Өвчний оношоор
Бусад 12
K25.2 Ходоодны шархлаа 1
X45 Спиртэнд санамсаргүй хортох өртөх 11
I21 Цочмог шигдээс 6
I61 Тархины харвалт 4
C22 Элэг ба элэгний доторх цөсний сувгийн 3
C92 Миелойд лейкеми 2
E05.0 Бамбай булчирхайн тархмал 1
A41.9 үжил тодорхойгүй шок 2
I10 Зүрхний ишемийн архаг өвчин 1
J18.8 Үүсгэгч нь тодорхойгүй хатгалгаа 3
K74.6 элэгний бусад тодорхойгүй цирроз 3
J44.0 Уушигны архаг бөглөрөлт өвчин 1
K70.3 Архины шалтгаант элэгний хатуурал 1

<table>
<tr>
<td>4.</td>
<td>Задлан шинжилгээний хувь</td>
<td>35.8%</td>
<td>25.7%</td>
<td>2024 онд Нийт нас баралт 382<br>
• 2023 он - 35.8% /n = 143/<br>
• 2024 он -25.7% /n =98/<br>
Нийт 98 тохиолдол задлан шинжилгээнд орсон. Үүнээс:<br>
➢ 20 тохиолдол нь Эмгэг судлалын үндэсний төвд<br>
➢ 10 тохиолдол нь Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн<br>
➢ 68 тохиолдол нь УНТЭ—т эмгэг судлалын задлан шинжилгээнд орсон<br>
<br>
<u>Нас баралт, задлан шинжилгээнд дараах эрх зүйн зохицуулалтыг мөрдөн ажиллаж байна</u><br>
➢ 2024 онд Эмгэг судлалын тусламж үйлчилгээний түгээмэл үйлдэл MNS 7015:2023 стандарт, ЭМС-ын 2023 оны А/447 тоот “Эмгэг судлалын шинжилгээнд баримтлах журам” тушаалыг тусламж үйлчилгээнд баримталж байгаатай холбоотой эмгэг судлалын шинжилгээнд орох тохиолдол буурсан.<br>
<table>
<tr><th>Нийт нас баралт</th><th>382/1.59%/</th></tr>
<tr><td>ЭСШ ороогүй<br>● А/447 тушаалаар чөлөөлөгдсөн-266<br>● Зайлшгүй орох шаардлагатай тохиолдол ороогүй-18</td><td>284</td></tr>
<tr><td>● ЭСШ орсон</td><td>98</td></tr>
<tr><td>● Онош тохирсон</td><td>94 /95,9%/</td></tr>
<tr><td>● Шүүх шинжилгээ</td><td>10</td></tr>
<tr><td>Үндсэн оношийн зөрүү<br>- УНТЭ эмгэг судлалын шинжилгээгээр -2<br>- Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн-2</td><td>4</td></tr>
<tr><td>Эхийн эндэгдэл</td><td>1</td></tr>
<tr><td>Конференц /тасагчилсан/<br>МЭТ, ЗТ, ЭЭТ, ЦЭСЧШСТ ,ЕМЗТ, ДШСДТ, ЯТТ тасгууд хоног болоогүй, тархины цус харвалтын шалтгаант гм/</td><td>55</td></tr>
</table>
</td>
</tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Задлан шинжилгээний хувь<br>35.8<br>25.7<br>2023<br>2024<br>Задлан шинжилгээний тоо /Тасаг, төв/<br>ЯТТ 10<br>ЭЭТ II 12<br>ЭЭТ I 58<br>ЭНМЗТ 1<br>НСМЗТ 1<br>БШГМЗТ 1<br>ЕМЗТ 6<br>МЭТ 1<br>ЗТ 4<br>ХСҮСТ 1<br>ДШСДТ 1<br>ЦЭСЧШСТ 1<br>ГЭТ 1 |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>


</td>
</tr>
<tr>
<td>5.</td>
<td>Үндсэн оношийн зөрүүний хувь</td>
<td>4.9%</td>
<td>4.1%</td>
<td>
2023 он Үндсэн онош зөрсөн- 4.9 % /7/<br>
2024 он Үндсэн онош зөрсөн- 4.1 % /4/ буурсан байна<br><br>
Үндсэн оношийн зөрүү 4 тохиолдол бүртгэгдсэн
<ul>
<li>2 тохиолдол УНТЭ-т орсон</li>
<li>2 тохиолдол шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнд орсон</li>
<li>ЭМТҮЧАБА-наас Эмнэлзүй эмгэг судлалын конференц хурлыг нийт эмч нарыг оролцуулан 5 удаа зохион байгуулж, үндсэн оношийн зөрүү, сургалтын ач холбогдол бүхий тохиолдол, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой алдаа тохиолдол эсэх, эхийн эндэгдэл хэлэлцэж дээрх дараах онолын мэдээллүүдийг хийв.</li>
</ul>


<table>
<tr><td>д/д</td><td>MNS 7015:2023 стандартын дагуу Эмнэлзүй, эмгэг судлалын хэлэлцүүлэг</td><td>Хэлэл цуулэг №</td><td>Хэлэлцсэн он сар/өдөр</td><td>Онолын мэдээллийн сэдэв</td></tr>
<tr><td>1</td><td>Үндсэн оношийн зөрүү</td><td>№1</td><td>2024/06/25</td><td>“Ходоодны өмөнгийн оношлогоо, эмчилгээ”</td></tr>
<tr><td>2</td><td>Сургалтын ач холбогдол бүхий тохиолдол</td><td>№2</td><td>2024/06/05</td><td>“ Цус сэлбэлтийн заалт”</td></tr>
</table>
</td>
</tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td>
<table>
<tr><td>3</td><td>Сургалтын ач холбогдол бүхий тохиолдол</td><td>№3</td><td>2024/09/03</td><td>“Мэс заслын үеийн хүндрэл, Wipple мэс заслын бэлтгэл, дараах хяналт”</td></tr>
<tr><td>4</td><td>Сургалтын ач холбогдол бүхий тохиолдол</td><td>№4</td><td>2024/10/22</td><td>“Зүрхний цочмог шигдээс түүний хүндрэл”</td></tr>
<tr><td>5</td><td>Эхийн эндэгдэл</td><td>№5</td><td>2025/01/06</td><td>“Артерийн битүүрээгүй цоргын гажиг”</td></tr>
</table>
<ul>
<li>ЭМТҮЧАБА-наас нас баралтын хэлэлцүүлгийг тасаг төвүүдэд зохион байгуулан, нийт 55 нас баралтын тохиолдолыг тасагчилсан байдлаар хэлэлцүүлсэн. Үүнд:</li>
<li>Эмнэлзүйн тасагчилсан хэлэлцүүлэг хийсэн тасгууд /ЭЭТ, МЭТ, ГЭТ, ЕМЗТ, ЗТ/Нас баралт болон алдаа тохиолдлын хэлэлцүүлэг 5 удаа зохион байгуулсан /ЦЭСЧШСТ, ЭЭТ, Сувилахуйн алба, ЗТ/</li>
</ul>
<u>MNS 7015:2023 стандартын дагуу</u><br>
Хэлэлцүүлэг 1:
<ul><li><u>Үндсэн оношийн зөрүүний тохиолдол</u></li></ul>
2024.6.25 УНТЭ-ийн хурлын танхимд хэлэлцүүлэг нийт эмч нар, суралцагч эмч нар оролцож хийгдсэн
<ul>
<li>Сургалтын ач холбогдолтой</li>
<li>Тусламж үйлчилгээний дутагдал эсэх</li>
</ul>
Хэлэлцүүлэг2:
<ul><li><u>Эхийн эндэгдэлийн тохиолдол</u></li></ul>
2025/01/07-нд УНТЭ-т зохион байгуулж УНТЭ-ийн нийт эмч нар, НЭМГ-ийн мэргэжилтэнүүд, ЭМЯ-ны эхийн салбар зөвлөлийн комисс ерөнхий мэргэжилтэн, ЭСҮТ-ийн эмгэг судлаач эмч нар, Өмнөговь аймгийн ЭМГ, НЭ-ийн эмч мэргэжилтэнүүд, ЭХЭМҮТ-ийн эмч нар хамтран оролцлоо
<ul>
<li>Эхийн эндэгдлийн тохиолдол /Эх барихын шууд бус шалтгаант/</li>
<li>Эмнэлзүй ба эмгэг судлалын үндсэн онош зөрсөн II бүлэг (Их зөрөө) (MNS7015:2023)</li>
<li>Эмнэлгийн тусламж үйлчилгээний дутагдал (Өмнөговь аймаг БОЭТ) –ийг хэлэлцсэн.</li>
</ul>
</td></tr>
<tr><td>6.</td><td>Эрчимт эмчилгээний орны фонд ашиглалтын хувь</td><td>ЭЭТ – 58%</td><td>ЭЭТ 53.2%</td><td></td></tr>
</table>

Энэ онд эрчимт эмчилгээний тасаг ЯТТ-аас 425, бусад тасгаас 350 хүн шилжин очиж хэвтэн эмчлүүлсэн байна.

Эрчимт эмчилгээний орны фонд ашиглалтын хувь 53.2%-тай байна




ЭЭТ 24 ортой ажилласан бөгөөд нийт 775 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн.

ЭМС 2022 оны А/475 тоот тушаал гарсантай холбоотой захирлын 2022 оны 10-р сарын 06-ны өдрийн А/296 тоот "Тусламж үйлчилгээний орны дээд хязгаар батлах тухай" тушаал гарч МЭТ, ЗТ тасгуудын 12 орыг ЭЭТ тасагт шилжүүлж нийт 24 ортой тусламж үйлчилгээ үзүүлж байна

| № | Үзүүлэлт | ЭЭТ I | ЭЭТ II | ЭЭТ III | Нийт |
|---|---|---|---|---|---|
| **1** | Хэвтэн эмчлүүлсэн | 567 | 203 | 5 | **775** |
| **2** | Нас баралт | 232(25.05%) | 72(35,4%) | | **304(39,2%)** |
| **3** | Хоног болоогүй нас баралт | 16 (4,2%) | 5(2,7%) | 0 | **21(2.7%)** |
| **4** | Дундаж ор хоног | 11.0 | 15.6 | 29.0 | **18,5** |
| **5** | Гемодиализ эмчилгээ | 172 хүнд | | | **172** |
| **6** | CRRT эмчилгээ | 79 хүнд | | | **79** |
| **7** | ECMO эмчилгээ<br>TPE эмчилгээ | ECMO-1хүн; TPE-5 хүн | | | **6** |
| **8** | Эмч нарын хамтарсан үзлэг | Өглөө бүр эмч нарын хамтарсан тойрон үзлэг хийгддэг. | | | |
| **9** | Давтан хэвтэлт | 9 | 4 | 0 | **13** |
| **10** | Эх, жирэмсэн | 3 | 0 | 0 | **3** |
| **11** | Гэртээ гарсан | 43 | 12 | 1 | **56** |
| **12** | Эмнэлэг хооронд шилжсэн | 12 | 0 | 0 | **12** |
| **13** | ЗАА-тай байсан дундаж хугацаа | 53 цаг | 117 цаг | 0 | **85 цаг** |
| **14** | Вазопрессор дэмжлэгтэй байсан дундаж хугацаа | 51 цаг | 34 цаг | 0 | **42 цаг** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7. | Давтан мэс засал хувь | 0.61% | 0.44% | **Давтан мэс заслын хувь:**<br><br>2023 онд нийт 15488 мэс засал хийгдсэн. Үүнээс:<br>➢ Давтан мэс засал 95 тохиолдол<br>➢ давтан мэс заслын хувь 0.61%-тай байсан.<br>2024 онд нийт 15169 мэс засал хийгдсэн. Үүнээс:<br>➢ Давтан мэс засал 70 тохиолдол<br>➢ Давтан мэс заслын хувь 0.46% болж өмнөх оны үеийнхээс 0.15% буурсан дүнтэй байна.<br><br><br>Давтан мэс засал ЕМЗТасаг/31/ болон БШГМЗТ/11/-т их тохиолдол орсон байна. |

**Давтан мэс засал / тасаг, төвөөр/**

| | 2023 | | 2024 хагас жил | 2024 жил | Анх мэс засал хаана хийгдсэн | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | УНТЭ | Бусад |
| **БШГМЗТ** | 15 | 24 | 11 | 11 | 11 | - |
| **ЕМЗТ** | 28 | 32 | 17 | 31 | 30 | 2 |
| **УАТ** | 4 | 6 | 5 | 8 | 8 | - |
| **ХҮСҮСТ** | 3 | 11 | 4 | 5 | 5 | - |
| **ЭШСТ** | 3 | 8 | 2 | 7 | 7 | - |
| **ЧХХМЗТ** | 1 | 2 | - | 1 | 1 | - |
| **ЭНМЗТ** | 1 | 2 | 1 | 1 | 1 | - |
| **НСМЗТ** | 1 | 4 | - | 1 | 1 | - |
| **МЭТМЗТ** | 1 | 5 | 2 | 5 | 5 | - |
| **ЗТМЗТ** | 1 | 2 | - | - | - | - |
| **БҮГД** | 58 | 95 | 42 | 62 | **70** | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8. | Мэс заслын дараах хүндрэлийн хувь | 0.49% | 0.44% | 2024 онд нийт 15169 мэс засал хийгдсэн. Нийт 70 /**0,46%**/ давтан мэс засал орсон , 68 / **0,44%/** мэс засал мэс заслын дараах хүндрэлийн улмаас мэс засал хийгдсэн<br><br>2024 оны Мэс заслын дараах нийт хүндрэлийн шалтгаан<br>• Шарх задарсан- 9 /13.2%/<br>• Цус алдалт- 23 /33.8%/<br>• Гэдэсний хүндрэл -14 /20.5%/<br>• Бугалааны хүндрэл-18 /26.4%/<br>• Бусад-4 /5.8%/ байна |






**Мэс заслын дараах хүндрэлийн хувь /тасаг,төвөөр/**

| Тасаг | Мэс заслын хүндрэл | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | цус алдалт | гэдэсний | шарх задарсан | Бусад / бүглаа, бэхэлгээ засах | Бүгд | Анхны мэс засал өөр эмнэлэгт |
| **БШГМЗТ** | **2** | **3** | **1** | **2** | **8** | **-** |
| **ЕМЗТ** | **9** | **11** | **8** | **8** | **36** | **2** |
| **УАТ** | **4** | **-** | **-** | **2** | **6** | **-** |
| **ХҮСҮСТ** | **1** | **-** | **-** | **5** | **6** | **-** |
| **ЭШСТ** | **3** | **-** | **-** | **1** | **4** | **-** |
| **ЧХХМЗТ** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |
| **ЭНМЗТ** | **2** | **-** | **-** | **-** | **2** | **-** |
| **НСМЗТ** | **1** | **-** | **-** | **-** | **1** | **-** |
| **МЭТМЗТ** | **1** | **-** | **-** | **4** | **5** | **-** |
| **Бүгд** | **23 /0.17%/** | **14 /0.09%/** | **9 /0.06%/** | **22 /0.14%/** | **68** | **2** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9. | Давтан хэвтэлтийн хувь | 30 хоног доторх давтан хэвтэлтийн хувь<br><br>1.3% | 30 хоног доторх давтан хэвтэлтийн хувь<br><br>0.5% | 2023 онд УНТЭ-т нийт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо 24437<br>2024 онд УНТЭ-т нийт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо 24069 |

30 хоног доторх давтан хэвтэлтийн хувь

➢ 2023 онд 186 үйлчлүүлэгч дунджаар 2-13 удаагийн давтамжтайгаар давтан хэвтсэн нь нийт хэвтэлтийн 1.3 %-ийг эзэлж байна
➢ 2024 онд 98 үйлчлүүлэгч дунджаар 2-4 удаагийн давтамжтайгаар давтан хэвтсэн нь нийт хэвтэлтийн 0.5% -ийг эзэлж байна




24 цагийн доторх давтан хэвтэлтийн хувь

➢ 2023 онд 26 тохиолдол 24 цаг дотор хэвтсэн давтан хэвтэн эмчлүүлсэн ба нийт хэвтэлтийн 1.32 %-ийг эзэлж байна
➢ 2024 онд 2 тохиолдол 24 цаг дотор хэвтсэн давтан хэвтэн эмчлүүлсэн ба нийт хэвтэлтийн 0.09 %-ийг эзэлж
24 цаг дотор давтан хэвтэлт буурсан байна.




| ХУГАЦАА | 2023 үйлчлүүлэгчийн тоо /хувь | 2024 үйлчлүүлэгчийн тоо/ хувь |
|---|---|---|
| 30 хоног дотор | 186 /1.3 % | 102 /0.5 %/ |
| 24 цаг дотор | 26/1.32 % | 2 /0.09% |

| Тасаг, төвүүд | Эхний хагас жил | Бүтэн жил | Хэвтсэн давтамж | | Давтан хэвтэлт хугацаа | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2 удаа | 3 удаа | 24 цаг | 30хоног |
| **ЕМЗТ** | 10 | 17 | 10 | - | 1 | 30 |
| **БШГМЗТ** | 11 | 8 | 11 | 1 | 1 | 16 |
| **ХҮСҮСТ** | 2 | 3 | 2 | - | - | 5 |
| **ЭШСТ** | - | - | - | - | - | - |
| **УАТ** | 16 | 12 | 13 | 4 | - | 28 |
| **НЭСТ** | 7 | 2 | 7 | - | - | 10 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td>
<table>
<tr><td>ЭНМЗТ</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>1</td></tr>
<tr><td>ЦЭСЧШСТ</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td>УХСТ</td><td>1</td><td>1</td><td>1</td><td>-</td><td>-</td><td>1</td></tr>
<tr><td>ЗТ</td><td>6</td><td>6</td><td>5</td><td>1</td><td>-</td><td>6</td></tr>
<tr><td>МЭТ</td><td>2</td><td>2</td><td>2</td><td>-</td><td>-</td><td>2</td></tr>
<tr><td>БТ</td><td>3</td><td>3</td><td>3</td><td>-</td><td>-</td><td>3</td></tr>
<tr><td></td><td>48</td><td>73</td><td>123<br>0.5%</td><td>6<br>/4.9%/</td><td>/2/<br>0.09%</td><td>/102/<br>0.5%</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>10</td><td>Тухайн мэргэжлийн чиглэлээр явуулсан мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт болон хамрагдагсдын тоо</td><td></td><td></td><td>УНТЭ-т 2024 онд 105 ажилчид мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан: Үүнд:<br>1. Төрөлжсөн мэргэжлийн эмч буюу мэс заслын олгох сургалт-12 эмч суралцаж байна.<br>2. Төрөлжсөн мэргэжлийн сувилахуй буюу мэдээгүйжүүлгийн сувилахуй-20, мэс заслын сувилахуй-19, дурангийн сувилахуй – 6, сэргээн засахын сувилахуй 1, техникч 6 нийт 52 сувилагч суралцаж байна.<br>3. Дээшлүүлэх чиглэлээр мэдээгүйжүүлгийн мэргэжил дээшлүүлэх-3 эмч, УАУ-ны мэргэжил дээшлүүлэх-2, дурангийн эмчийн мэргэшүүлэх сургалт – 9, чих хамар хоолойн мэргэжил дээшлүүлэх сургалтанд - 4 хүн нийт 18 эмч суралцаж байна.</td></tr>
<tr><td>11</td><td>Тухайн мэргэжлийн чиглэлээр хийж буй:<br>- Судалгаа, эрдэм шинжилгээний хүлээлгэн өгсөн тайлан<br>- Хэвлэгдсэн сэтгүүл болон хэвлэл<br>- Эрдмийн зэрэг хамгаалсан хүний тоо</td><td></td><td></td><td>Байгууллагын хэмжээнд 2024 онд 2 сэтгүүл /илтгэлүүдийн эмхэтгэл/ хэвлэгдсэн. Үүнд.<br>1. “Эрдмийн чуулган – 45”. Тус чуулганд 2024 онд давхардсан тоогоор УНТЭ-ийн нийт 229 эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнууд оролцож, илтгэлээ хэвлүүлсэн болно.<br>➢ Дотрын чиглэлийн илтгэл хэвлүүлсэн – 11 багийн 42 эмч<br>➢ Мэс заслын чиглэлийн илтгэл хэвлүүлсэн – 16 багийн 76 эмч<br>➢ Сувилахуйн чиглэлээр илтгэл хэвлүүлсэн – 22 багийн 93 сувилагч<br>➢ НЭМ, удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр илтгэл хэвлүүлсэн – 9 багийн 18 эмч<br>2. “Эмнэлзүйн ховор тохиолдлын үндэсний чуулган -5”<br>➢ 19 багийн 58 эмч эмнэлзүйн тохиолдлын илтгэл хэвлүүлсэн байна.<br>➢ Олон Улсын impact factor өндөртэй болон чансаа өндөр сэтгүүлд нийт 18 эмч өгүүлэл хэвлүүлсэн байна.<br><br>Дүгнэлт: 2024 онд олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд нийт давхардсан тоогоор нийт 305 эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтан илтгэл, өгүүлэл хэвлүүлсэн байна.<br>3. Эрдмийн зэрэг хамгаалсан хүний тоо – Магистр хамгаалсан 5</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| 12 | Сэлгэн ажиллуулсан эмч, сувилагчийн тоо (хөдөө орон нутаг болон эмнэлэг хооронд) | ЗХНА | ЗХНА | 2024.12.31-ний өдрийн байдлаар УНТЭ-ийн 847 орон тоонд харьцуулан тооцоолов.<br>1. 2024 онд байгууллага дотроо **44** сувилагч, тусгай мэргэжилтэнг сэлгэн ажиллуулсан, **11** ажилтанг шилжүүлэн томилсон.<br>2. Хөдөө орон нутагт<br>➢ Чих хамар хоолой судлал, мэс заслын тасгийн их эмч О.Байгалмаа “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд 160 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан.<br>➢ Эрүү нүүрний мэс заслын тасгийн их эмч Б.Хонгор, их эмч Х.Анударь “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд Төв аймаг, Говьсүмбэр аймгууд, ХУД 12-р хороо, Өлзийт хороололд эрүү нүүрний мэс заслын урьдчилан сэргийлэх үзлэг хийж шаардлагатай тохиолдлуудыг УНТЭ-ийн Эрүү нүүрний мэс заслын тасаг руу илгээж тусламж үйлчилгээг үзүүлсэн.<br>➢ Дотоод шүүрэл судлал, диабетийн төвийн их эмч Б.Мөнх-Од 2024.03.06-15 хооронд ЭМЯ-ны УОК-н шуурхай бүлгийн багтай хамтран Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгуудад ажилласан.<br>➢ Дотоод шүүрэл судлал, диабетийн төвийн дарга, их эмч С.Янжмаа 2024.09.13-15 хооронд Өмнөговь аймгийн БОЭТ-д урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, зөвлөгөөг өгч ажилласан.<br>➢ Дүрс оношлогооны төвийн эмч нар Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Ховд, Өвөрхангай, Дархан, Өмнөговь, Төв, Архангай, Говь-Сүмбэр зэрэг 10 аймагт урьдчилан сэргийлэх үзлэг, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>➢ Дүрс оношлогооны төвийн дарга, их эмч Г.Өрнөлтсайхан Ховд аймгийн БОЭТ-д 2024 оны 06 дугаар сард 3 өдөр ангиографийн тусламж үйлчилгээг хамтран ажиллаж зөвлөгөө өгсөн.<br>➢ Дотоод шүүрэл судлал, диабетийн төвийн эмч, сувилагч нарын баг Орхон, Өвөрхангай аймгийн БОЭТ-ийн нийт 360 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд “Чихрийн шижингийн өөрийн хяналт” “Инсулин эмчилгээ хийх, тарих арга техник” “Захын цусанд глюкоз тодорхойлох арга техник” сэдвийн дагуу лекц болон дадлагын сургалтуудыг зохион байгуулсан.<br>➢ Дүрс оношлогооны төвийн эмч нар, Ерөнхий мэс заслын тасгийн сувилагч М.Амарзаяа нарын бүрэлдэхүүнтэй баг Увс аймгийн Бөхмөрөн сумын эрүүл мэндийн төвд 2024.05.22-23-нд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо, эмчилгээг зохион байгуулсан.<br>➢ Нүд судлал, мэс заслын багийн эмч нар Вирту сангийн хамтын ажиллагааны хүрээнд Ховд аймгийн БОЭТ-д 2024.05.29-2024.06.06 хооронд нүдний үзлэг, оношилгоо, мэс заслын тусламж үйлчилгээний ажлын байран дээрхи сургалтыг зохион байгуулсан.<br>➢ Нүд судлал, мэс заслын багийн эмч Д.Энхзул Orbis төслийн олон улсын нүдний эмч нартай хамтран орон нутагт очиж орон нутгийн нүдний эмч нарт жижиг зүслэгээр болор авах, болор суулгах мэс заслыг заасан.<br>➢ Уушги харшил судлалын төвийн нарын баг ХУД-ийн 170 гаруй гэр хорооллын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | иргэдэд нарийн мэргэжлийн тусламж амралтын өдрүүдээр үзүүлж, эмч нарт арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.<br>➢ Өмнөговь аймгийн БОЭТ-д нийт 80 иргэнд уушгины эмчийн үзлэг хийж, 2 үйлчлүүлэгчийг уушгины дурангийн оношилгоо хийсэн.<br>➢ Эрүү нүүрний мэс заслын тасгийн эрхлэгч П.Булган, ахлах сувилагч Г.Батзаяа нар Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эрүү нүүрний мэс заслын тасагт “Шүдний гаралтай хүндрэл, мэс заслын дараах сувилахуй” сэдэвт ажлын байрны сургалт зохион байгуулж мэс засал хамтран ажилласан.<br>➢ Рафиел ТББ-тай хамтарсан төслийн хүрээнд Чих хамар хоолой судлал, мэс заслын тасгийн эмч Д.Уянга сургуулийн насны сурагчдын сонсгол бууралтын тархалтыг илрүүлэх судалгаа хийх зорилгоор ЕБС-ийн 2, 40, 57, Ирээдүй монгол сургуулиудад 594 сурагч хамрагдсанаас сонсголын бууралт 77/13.5%/ хүүхдэд илэрсэн. Нийслэлийн хэмжээний 5 дүүргийн 1713 хүүхдэд шинжилгээ хийгдсэн.<br>➢ Чих хамар хоолой судлал, мэс заслын тасгийн их эмч О.Байгалмаа Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн дундах сонсгол бууралтын тархалтын судалгааг 9 дүүрэгт 1900 хүнд хийх төлөвлөгөөтэй байгаа ба СХД-ийн 4, Налайх дүүргийн 1 хорооны 500 орчим насанд хүрэгчдэд эрт илрүүлэг хийсэн. |
| 13 | Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын үзлэгт хамрагдах хувь | 2023 онд 61.7 % | 2024 онд 85% | 2024 оны ажилтны урьдчилан сэргийлэх үзлэгийг 2024 оны 4 сараас эхэлсэн бөгөөд лабораторийн багц шинжилгээнд 838 ажилтнаас 760 ажилтан хамрагдсан. Хавдрын 4 төрлийн маркер үзэх шинжилгээнд нийт 489 ажилтан бүртгүүлсэнээс 422 ажилтан хамрагдсан. Дүрс оношилгооны буюу өндөр өртөгт MRI, CT багажийн шинжилгээнд нийт 300 ажилтан хамрагдах хүсэлт ирүүлсэнээс эхний 11 сарын байдлаар КТГ-ийн шинжилгээнд 84, MRI шинжилгээнд 95 ажилтан хамрагдсан байна.<br>Байгууллагын ерөнхий захирлын 2024.10.18-ны өдрийн Б/573 тоот тушаалаар ажилчдын эрүүл мэнд хариуцсан эмчээр Гастроэнтерологийн төвийн их эмч Ц.Даштуяаг томилон ажиллуулж байгаа бөгөөд ажилтнуудын эрүүл мэндийн үзлэг нэгдсэн байдлаар 12.16-ны өдрөөс эхэлсэн. |
| 14 | Нэг өвчтөнд ногдох эмийн зардал | 2023 онд<br>1.449. 450 сая төг | 2024 онд<br>........... | |
| 15<br>16 | Тухайн жилд тасралтгүй сургалтын кредитын шаардлага хангасан:<br>➢ Эмчийн хувь (215) | 100 % | 100 % | Нийт эмнэлгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд 100% багц цагийн сургалтанд хамрагдаж байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 17 | ➢ Сувилагчийн хувь (сувилагч 300, тусгай мэргэжилтэн 96) | 100 % | 100 % | |
| 18 | Байгууллагуудын өрийн хэмжээ | Өрийн хэмжээ 18.6 тэрбум | Өрийн хэмжээ 25.7 тэрбум | УНТЭ болон ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний дагуу 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар тасалбар болгосон авлага 16.7 тэрбум төгрөг.<br><br>Нягтлан бодох бүртгэлийн зарчмаар 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар тасалбар болгосон өглөг 25.7 тэрбум төгрөг, дансны үлдэгдэл 3.6 тэрбум төгрөг. |

## 2.2 Өвөрмөц үзүүлэлт

2.2.1 Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв

| № | Шалгуур үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Эмчилгээ, оношилгоо, сувилахуйн тусламж үйлчилгээнд шинэ арга технологи нэвтрүүлсэн тоо, шинэ санаачлага | 40 технологи | 39 технологи | УНТЭ нь 2024 онд дараах 39 эмчилгээ, оношилгооны шинэ технологуудыг бие дааж болон гадаад эмч нартай хамтран нэвтрүүлсэн.<br>1. Элэг шилжүүлэн суулгах мэс засалд суулгац элэгний нөхөн засалд гялтан хальс ашиглах мэс засал<br>2. Бамбайн дэргэдэх булчирхайн анхдагч аденома түлэх (RFA) эмчилгээ<br>3. Хэвлийн дурангий аргаар Wipple мэс засал<br>4. Single insional-intra gastric<br>5. resection мэс засал<br>6. Thoracoscopic pleural decortication мэс засал<br>7. Лазерын тусламжтай дөрөөний /Stapedectomy/ мэс засал<br>8. Чихний гадна сувгаар дамжуулан дурангийн аргаар нүүрний мэдрэлийн хавдрыг /Schwannoma/ авах мэс засал.<br>9. Нойрон дунд амьсгал тасалдах эмгэгийн унтуулгатай дурангийн шинжилгээний арга<br>10. Үндэсний хэмжээнд үгийн аудиометрийн шинжилгээг нэвтрүүлсэн<br>11. Эвэрлэг шилжүүлэн суулгах мэс засал (Virtue foundation-тай хамтран)<br>12. Нүдний даралт бууруулах MIGS мэс засал (Virtue foundation-тай хамтран)<br>13. Альбумин диализ (single pass albumin dialysis-SPAD)<br>14. Дурангийн хэт авиан хяналтан дор ходоодны өргөссөн судсыг боох эмчилгээний технологи (EUS)<br>15. Цусны хавдрын бай эмчилгээний 2-3 дугаар эгнээний бай эмчилгээг нэвтрүүлсэн<br>16. Үүдэл эсийг шүүх, боловсруулах хөлдөөх шинэ технологи |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | 17. Гуурсан хоолойн хэт авиан трансбронхиал аспирацийн биопси хийх ( EBUS-TBNA) арга<br>18. Хиймэл оюун ухааны тусламжтай Өвдөгний үе солих мэс засал<br>19. Төрөлхийн согог болон том хэмжээний гэмтлийн үед 3D принтер ашиглан хувь хүнд тохирсон протезын мэс засал<br>20. Яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх, мөч хадгалах мэс засал<br>21. Төрөлхийн тагнайн сэтэрхий нөхөх мэс заслын дараах зөөлөн тагнайн дутагдлыг Залгиурын арын далбан /Posterior Pharyngeal Flap/-р нөхөн сэргээх мэс засал<br>22. Галт зэвсгийн улмаас үүссэн тагнайн согогийг Хэл болон хацрын өөхөн эдийн далбан /Tongue and buccal fat flap/-р нөхөн сэргээх мэс засал<br>23. Эрүүний ясны хэт хөгжлийн улмаас эрүүний хэлбэр алдагдсан үед эрүүний ясны хэлбэр засах, зажлуурын булчинг багасгах мэс засал<br>24. Ортогнатик буюу шаамий засах мэс засал<br>25. Нойрсох үеийн амьсгал тасалдах /Obstructive Sleep Apnea/ 3 тохиолдолд Хүүхэн хэл-зөөлөн тагнай-залгиурын ханыг засах, хэлний булчинг урагш сойж бэхлэх мэс засал<br>26. Мөч хадгалах зорилгоор доод мөчдийн артерийн судасны бөглөрлийн үед венийн судсыг артержуулах мэс засал<br>27. Артери венийн фистулын мэс заслын алсын хүрцэд микроскопын тусламжтайгаар судас залгах бичил мэс засал<br>28. NGS технологи ашиглан HLA typing 11 локуст тодорхойлох шинжилгээ<br>29. NGS технологи iSeq 100 төхөөрөмж дээр Ходоод, бүдүүн шулуун гэдэс, хөх, өндгөвч болон бусад хавдрын оношилгоонд шаардлагатай 113 генийн мутац тодорхойлох шинжилгээ<br>30. NGS технологи iSeq 100 төхөөрөмж дээр Цусны эмгэгийн оношилгоонд шаардлагатай 40 бай DNA, 29 RNA fusion driver генийн мутац тодорхойлох шинжилгээ<br>31. Байгалийн нүхээр мэс заслын сорьцыг гаргах болон хэвлийн дотор залгалт хийх технологи (TAMIS ажилбар)<br>32. Давсагны хорт хавдрыг хэвлийн дурангаар авах мэс засал<br>33. Давсагны хавдрыг шээдэг сүвээр дурандаж лазераар хуулан авах мэс засал<br>34. Тархины судасны хагараагүй цүлхэнд WEB stent-ийг байрлуулах мэс засал<br>35. Тархины цус тасалдах харвалт болсон өвчтөнд судсан дотроос баруун талын нугаламын артерийн бөглөрлийг онгойлгож, стент тавих мэс засал<br>36. Харвалтын үндэсний шалгуур бүлэн уусгах эмчилгээ, бүлэн авах эмчилгээ /time/<br>37. Хөлийн tarsal tunnel syndrome мэс засал эмчилгээ<br>38. Deb-TACE буюу элэгний анхдагч хавдрын тэжээгч судсыг химийн тариа ялгаруулагч бөмбөлөг материалаар бөглөх эмчилгээ<br>39. Rituximab эмчилгээг стеройд тэсвэртэй Мембраноз нефропатийн үед хэрэглэх нь |

<table>
<tr>
<td>2.</td>
<td>Эмнэлгээр үйлчлүүлэх үедээ унаж, гэмтсэн тохиолдлын тоо</td>
<td>Тохиолдлын тоо-5</td>
<td>Тохиолдлын тоо- 1</td>
<td>
<table>
<tr><td>01/02</td><td>2-Таагүй тохиолдол</td><td>ЦЭСЧШСТ</td></tr>
</table>
Авсан арга хэмжээ
<ul>
<li>ЭМС-ын 2024 оны А/112 тоот тушаалын дагуу “Алдаа тохиолдолын нэгдсэн санд Таагүй тохиолдолоор бүртгэн, ЭМХТ-д мэдээллэсэн</li>
<li>2024 оны 01 сарын 03-ны өдөр ЦЭСЧШСТ Чанарын багын хурал ЭМТҮЧАБА-тай хамтарсан хийсэн.</li>
<li>Төлөвлөгөө гаргаад, дүрэм, стандарт, журам танилцуулах дотоод сургалт хийх ,эмчлүүэлгчийг зөв танин тодруулах үйл ажилагааг сайжруулах арга хэмжээ авагдсан. Үйлчлүүлэгчийг ЦЭСЧШСТ-д хэвтүүлэн эмчилгээг хийсэн</li>
</ul>
</td>
</tr>
<tr>
<td>3.</td>
<td>Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)</td>
<td>Тохиолдлын нийт тоо –3</td>
<td>Тохиолдлын нийт тоо –4</td>
<td>
Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын 6 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 4 тохиолдол нь 0-74 насанд бүртгэгдсэн нас баралт байна.
<ul>
<li>Архангай /0.1 промиль/-1 тохиолдол</li>
<li>Дундговь /0.1 промиль/-1 тохиолдол</li>
<li>Увс /0.11 промиль/-1 тохиолдол</li>
<li>Өвөрхангай /0.08 промиль/-1 тохиолдол</li>
</ul>
<table>
<tr><th></th><th>Тасаг</th><th>Ор хоног</th><th>Онош</th><th>Тайлбар</th></tr>
<tr><td>1.</td><td>ЭЭТ ЕМЗТ</td><td>8</td><td colspan="2">Ходоодны шархлаа, цочмог цус алдалт оношоор хэвтэн яаралтай журмаар ерөнхий мэдээ алдуулалтан дор нээлттэй аргаар хэвлийн нээж шалгах, ходоодны цус тогтоох мэс засал мэс засалд орж, мэс заслын дараа ЭЭТ-руу шилжсэн</td></tr>
<tr><td>2.</td><td>ЭЭТ ЕМЗТ</td><td>3</td><td colspan="2">Цэргийн төв эмнэлгээс УНТЭ-н ЯТТ- руу явуулсан.<br>УНТЭ-ийн ЯТТ-гт ирэх үед ухаан санааны байдал муудсан, шоктой, оношлогоо, эмчилгээг хийж, толгойн болон хэвлийн тодосгогчгүй КТ, ходоодны дуран хийж ЭЭТ-т R58, R57.1 оношоор шилжүүлж авсан. Ходоодны бага махиа хэсгийн аварга шарх, Шархны цус алдалт, хүнд зэргийн цус багадалт</td></tr>
<tr><td>3.</td><td>ЭЭТ ЕМЗТ</td><td>8 цаг</td><td colspan="2">УНТЭийн ЯТТ ирсэн.<br>2023 оны 10 сарын 01-нд Бүдүүн гэдэсний түгжрэл оношоор мэс засалд орж бүдүүн гэдэсний хавдар оношлогдсон. биеийн байдал хүнд байгаа тул эрчимт эмчилгээний тасагт-1 үргэлжлүүлэхээр R57.9 заалтаар хүлээж авсан Шархны цочмог цус алдалт. Хүнд зэргийн цус багадалт.</td></tr>
</table>
</td>
</tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><td></td><td></td><td></td><td>Ходоодны гарах хэсгийн аварга, цоорсон шарх. К25.2 Хэвлий нээж шалгах, ходоодны бага махиаг тайрах, их махиа, 12 хуруу гэдсийг мухарлаж оёх, цус алдалт тогтоох мэс засал</td></tr>
<tr><td>4.</td><td>ЭЭТ<br>ЕМЗТ</td><td>3</td><td>УНТЭ-ЯТТ ирсэн.<br>Хэвлийн КТГ хийлгэхэд хөндийт эрхтний цооролын шинж илэрсэн тул яаралтай журмаар ЕМЗТ-т хэвтсэн Хэвлийн тархмал гялтантас /K65.0/. Элэгний гадаргуу глиссон бүрхүүл хайлах. Дээрхи гэдэс ходоодны гарах хэсгийн цоорсон шарх шархлаа /K25.1/ Хэвлийг нээж шалгах дээрхи гэдэсний эхлэл ходоодны гарах хэсгийг тайрах ходоодыг нарийн гэдэстэй залгах , нарийн гэдэсийг нарийн гэдэстэй залгах. цэсний хүүдий авах, хэвлий угааж гуурсдах, сөрөг зүслэг хийх мэс засал хийгдсэн.</td></tr>
</table>
</td>
</tr>
<tr>
<td>4.</td>
<td>Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд )</td>
<td>Тохиолдлын нийт тоо – 0</td>
<td>Тохиолдлын нийт тоо – 2</td>
<td>
Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралт 3 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 2 тохиолдол нь 0-74 насанд бүртгэгдсэн нас баралт байна.
<ul>
<li>Сэлэнгэ /0.09 промиль/-1 тохиолдол</li>
<li>Дорнод /0.11 промиль/-1 тохиолдол</li>
</ul>
<table>
<tr><th></th><th>Тасаг</th><th>Ор хоног</th><th>Онош</th><th>Тайлбар</th></tr>
<tr><td>1.</td><td>ЭЭТ</td><td>14</td><td>Артерийн даралт ихсэх өвчин II-р зэрэг I10 Бөөрний архаг дутагдал N18 Уреми R39.2 Уремийн энцефалопати Зүрхний ишеми өвчин, Ишемийн кардиомиопати, Зүрхний архаг дутагдал, Зүрхний гаралтай шок , Тархины зулайн дэлбэнгийн цус харвалт, Хоёрдогч идээт менингит</td><td>2024/09/15-нд ГССҮТ-ЭЭТ руу шилжсэн. ГССҮТ-ЭЭТ-д эмчлүүлж байх хугацаанд бөөрний дутагдал нэмэгдэж, ухаан санааны байдал сайжралгүй байсан тул УНТЭ-ийн ЯТТ-д ирж, R40 заалтаар ЭЭТ 1-т шилжүүлж авсан.</td></tr>
<tr><td>2.</td><td>ЭЭТ</td><td>20</td><td>Тархины цус харвалт Артерийн даралт ихсэх өвчин Цөсний замын</td><td>Нойр булчирхайн бусад хэсгийн хавдар оношоор төлөвлөгөөт журмаар ЕМЗТ-т хэвтэж</td></tr>
</table>
</td>
</tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хавдар, элэгний үсэрхийлэл<br>2024/10/02нд хэсгийн мэдээ алдуулалт дор ЭХО болон Флюоро хяналтан дор элэгний 3-р сегментийн posterior branch of intrahepatic biliary duct-д external-internal PTBD гуурсыг байрлуулах мэс засал хийгдсэн ЕМЗТ-т 2024 оны 10 сарын 04 өдөр 18 цагийн орчимд хүчтэй огисны дараагаас ухаан санааны байдал муудаж унтаарч эхэлсэн тул ЭЭТ-ийн эмч дуудаж үзүүлэн толгойн КТГ шинжилгээ хийлгэхэд бүх ховдолд цөмөрсөн харвалт үүссэн байсан тул R40.2, I61 заалтаар ЭЭТ-т шилжүүлэн авсан. |
| 5. | Гуурсан хоолойн өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-44 насны 10 000 хүн амд) | Тохиолдлын нийт тоо – 0 | Тохиолдлын нийт тоо – 0 | Сүүлийн 3 жил тохиолдол бүртгэгдээгүй байна. |
| 6. | Мухар олгойн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд) | Тохиолдлын нийт тоо – 1 | Тохиолдлын нийт тоо – 0 | УНТЭ-т 2024 оны эхний хагас жилд нийт 376 мухар олгойн хагалгаа хийгдсэнээс нас баралтын тохиолдол бүртгэгдээгүй байна. |
| 7. | Цөсний чулуу, цөсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд) | Тохиолдлын нийт тоо - 4 | Тохиолдлын нийт тоо - 4 | 2024 онд УНТЭ-т нийт 1602 цөсний хагалгаа орсны 93.2% (n=1493) нь дурангаар орсон.Цөсний чулуу болон үрэвслийн шалтгаант нас баралтын 8 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 4 тохиолдол нь 0-74 насанд бүртгэгдсэн нас баралт байна.<br>• Баянхонгор /0.22 промиль/-2 тохиолдол<br>• Завхан /0.13 промиль/-1 тохиолдол<br>• Улаанбаатар /0.005 промиль/-1 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.<br>• Улаанбаатар /0.005 промиль/-1 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. |

| | Тасаг | Ор хоног | Онош | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | ГЭТ | 6 | Цөсний суваг бөглөрөх. Хоёрдогч цөсөн элэгний хатуурал. Цөсний замын нарийсал Дэлүүний томрол, үүдэн венийн бүлэн, улаан хоолой венийн судасны өргөсөл, хэвлийн шингэн, элэг бөөрний хам шинж, Элэгний энцефалопати. Элэг солиулсаны дараах элэгний буглаа. Хоёрдогч дунд зэргийн цус багадалт. Элэг солиулсаны дараах байдал. | 07/28-нд Peritonitis болж нээлттэй хэвлийн хөндий угаах мэс засалд орсон. Тухайн үед DS: Liver abscess оношлогдсон.<br>2023/08 сард DS: PV thrombosis оношлогдож тухайн эмнэлэгтээ сэтгүүрдэх мэс ажилбарт орсон. |
| 2. | ЭЭТ ЕМЗТ | 8 | Цочмог идээлж цоорсон цөсний хүүдийтэс К82.2<br>2024/09/03-нд Амь насны заалтаар яаралтай журмаар ерөнхий мэдээ алдуулалт дор нээлттэй аргаар цөсний хүүдий авах, элэгний буглаа нээх мэс засал 51.22<br>Артерийн даралт ихсэлт 3-р зэрэг I15.9 | СХДНЭ- оношийн дагуу УНТЭ-рүү ирж УНТЭ-ЕМЗТ-т хэвтээд яаралтайгаар цөсний хүүдий авах мэс засалд орсон хэвлий нээж шалгах мэс заслын үед шокийн байдал гүнзгийрээд байсан тул УНТЭ-ЭЭТ-т шилжүүлэн хэвтүүлэв. |
| 3. | ЕМЗТ | 15цаг 15 минут | Цочмог идээлж үхжиж цоорсон цөсний хүүдийтэс /К82.2/ | 2024/9/28 хүлээн авах мэс заслын жижүүр эмчид үзүүлэн яаралтай журмаар мэс засалд орохоор УНТЭ-ЕМЗТ-т хэвтүүлэв |
| 4. | ЕМЗТ | 7 | Цөсний ерөнхий сувгийн чулуу К83.1 Эсгэгийг шалтгаант тархмал гялтантас, сэмжний өөхөн үхжил, 2догч нойр булчирхайн цочмог үхжилт үрэвсэл, Артерийн даралт ихсэх өвчин | УНТЭ-ЯТТ-н тасагт ар гэрийн хамт Япон -Монгол эмнэлэг Цөсний ерөнхий сувгийн чулуу оношоор ERCP эмчилгээ хийлгэх саналтайгаар УНТЭ-ЯТТ цочмог цөснийхүүдий тэс оношоор яаралтай журмаар ходоодны дурангаар цөсний ерөнхий сувгийн чулуу авах, хэвлийн дурангийн аргаар цөсний хүүдий авар мэс засал хийлгэхээр УНТЭ-н ЕМЗТ-т хэвтэв. |

<table>
<tr><td>8</td><td>Тархинд цус харвалтын шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)</td><td>Тохиолдлын тоо -43</td><td>Тохиолдлын тоо -36</td><td>2024 онд тархины цус харвалт оноштой 460 хэвтэн эмчлүүлсэнээс 37,2% (n=171) мэс ажилбар хийгдсэн байна. Нийт тархины цус харвалт оношоор хэвтэн эмчлүүлэгчдийн 9,1% (n=42) нас барсан бол үүнээс 36 тохиолдол нь 0-74 насанд бүртгэгдсэн нас баралт байна.<br>Тархинд цус харвалтыг харъяалалаар ангилахад:<ul><li>Архангай /0,10 промиль/-1 тохиолдол</li><li>Баянхонгор /0.11 промиль/-1 тохиолдол</li><li>Булган /0.48 промиль/-3 тохиолдол</li><li>Говь-Алтай /0.34 промиль/-2 тохиолдол</li><li>Дархан-Уул /0.09 промиль/-1 тохиолдол</li><li>Завхан /0.39 промиль/-3 тохиолдол</li><li>Орхон /0.09 промиль/-1 тохиолдол</li><li>Өвөрхангай /0.24 промиль/-3 тохиолдол</li><li>Төв /0.8 промиль/-8 тохиолдол</li><li>Хөвсгөл /0.14 промиль/-2 тохиолдол</li><li>Улаанбаатар /0.07 промиль/-11 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна</li></ul>
<table>
<tr><th>Он</th><th>Тархины цус харвалт оноштой хэвтэн эмчлүүлсэн</th><th>Ангиографи хийсэн тоо/хувь</th><th>Нийт нас баралтын хувь/тоо</th></tr>
<tr><td>2023</td><td>591</td><td>(n=456) 77.1%</td><td>7.5% (n=43)<br>- ЭЭТасагт-37<br>- МЭЭТ-3 тохиолдол</td></tr>
<tr><td>2024</td><td>460</td><td>(n=171) 37.2%</td><td>7.8% (n=36)<br>- ЭЭТасагт -32<br>- МЭТ-4 тохиолдол</td></tr>
</table></td></tr>
<tr><td>9</td><td>Зүрхний шигдээсийн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд)</td><td>Тохиолдол нийт тоо -7</td><td>Тохиолдол нийт тоо -8</td><td>2024 онд УНТЭ-т нийт зүрхний шигдээс оношоор 224 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэний 98.7% (n=221) ангиографийн оношлогоо болон эмчилгээ хийлгэсэн байна. Нийт зүрхний шигдээс оношоор хэвтэн эмчлүүлэгдчийн 4% (n=9) нас барсан бол үүнээс 8 тохиолдол нь 0-74 насанд бүртгэгдсэн нас баралт байна.<br>Зүрхний шигдээс өвчнөөр нас баралтын харьяалалаар ангилахад:<ul><li>Булган /0.16 промиль/-1 тохиолдол</li><li>Өмнөговь /0.26 промиль/-2тохиолдол</li><li>Сэлэнгэ /0.09 промиль/-1 тохиолдол</li><li>Улаанбаатар /0.024 промиль/-4 тохиолдол</li></ul>бүртгэгдсэн байна.</td></tr>
</table>

| Он | Зүрхний шигдээс оноштой хэвтэн эмчлүүлсэн | Ангиографи хийсэн тоо/хувь | Нийт нас баралтын хувь/тоо | Ангиограф нас баралт |
|---|---|---|---|---|
| 2023 | 159 | (n=150) 96.1% | 4.5% (n=7) | 4-ангиограф оношилгоо эмчилгээ ТСДО/ТСДЭ |
| 2024 | 224 | (n=221) 98.7% | 4% (n=8) | 6-ангиограф оношилгоо эмчилгээ ТСДО/ТСДЭ |

Тайлан боловсруулсан:
Эмнэлзүйн албаны статистикч их эмч — Э.Энх-Эрдэнэ
ЭМТҮЧАБА-ны дотор хариуцсан чанарын менежер — Д.Ганчимэг
ЭМТҮЧАБА-ны мэс засал хариуцсан чанарын менежер — Э.Цэрэннадмид

Тайлан хянасан:
ЭМТҮЧАБА-ны дарга — М.Одсүрэн